

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгэнэ.
- (*) тэмдэгтэй даалгавруудыг хөгжим болон дуу сонссоны дараа гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн хариултаас зөвхөн нэг хариултыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

***Хөгжмөө сонсоод 1-5 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.**



Хөгжмийн зохиолч энэхүү зохиолоороо “Харанхуйгаас гэрэл гэгээ рүү, амьдралд тохиолдох саад тотгорыг цуцалтгүй тэмцлийн үр дүнд ялан дийлж эрх чөлөөнд хүрнэ” гэсэн санааг илэрхийлэхийг зорьсон.

1. *Бүтээлийн түүхийг уншаад ямар зохиол болохыг сонгоно уу.

- A. “5 дугаар симфони” B. “40 дүгээр симфони”
C. “94 дүгээр симфони” D. “Төгсөөгүй симфони”

2. *Хэмнэлүүдийг анхааралтай ажиглаад тогшиж үзээрэй. Чиний бодлоор зохиолын хэмнэл аль нь вэ? Тохирохыг сонгоно уу.

A.

B.

C.

D.

3. *Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхөд тохирохыг сонгоно уу.

- A. Уянгын зөөлөн B. Баатарлаг, эрч хүчтэй
C. Уйтгар гунигтай D. Хөгжилтэй

4. *Соль түлхүүрийн ард байрлах тэмдгийн үүргийг зөв тодорхойлсон хувилбарыг сонгоно уу.

- A. Эгшгийг хагас өнгөөр дээшлүүлэх үүрэгтэй.
B. Эгшгийг хагас өнгөөр доошлуулах үүрэгтэй.
C. Эгшгүүдийг огцом тасалдангуй хөгжимдөх үүрэгтэй.
D. Эгшгүүдийг тасралтгүй үргэлжлүүлэн хөгжимдөх үүрэгтэй.

5. *Зохиолыг хөгжмийн ямар бүрэлдэхүүнд бичсэн байна вэ?

A.



B.



C.



D.



*Ж.Чулуун “Уран хас” зохиолыг сонсоод 6-9 дүгээр даалгаврыг гүйцэтгээрэй.

6. *Хөгжмөө анхааралтай сонсоорой. Хөгжмийн урлагийн ямар төрлөөр бичсэнийг олоорой.

A. Дуурь- Хөгжим, яруу найраг, театр, бүжиг, дүрслэх урлаг гэх мэт урлагийн олон төрлүүдийн нийлбэрээс бүрдсэн зохиол.

B. Бүжгэн жүжиг- Бүжиг, хөгжмийн нийлэмжээр дүрслэл, утга агуулгаа илэрхийлдэг бүтээл.

C. Сонат: Зөрчилт хөгжим- гоцлол цөөхүүл хөгжмийн нэг төрөл. Сонгодог зөрчилт хөгжим ихэвчлэн 3 ангитай байдаг.

D. Симфони- Дан хөгжмийн зохиолын хамгийн том төрөл болох сонгодог симфони нь 4 ангитай байдаг.

7. *Сонссон зохиолыг хөгжмийн ямар бүрэлдэхүүнд бичсэн байна вэ?

A.



B.




C.



D.



8. *Ноот бичлэгийг анхааралтай ажиглаад, аялгууны айзам хэмжээнд тохирохыг сонгоно уу.



A.

4/4

B.

2/4

C.

6/8

D.

3/4

9. *Ноот бичлэгт байгаа  тэмдгийн үүргийг зөв тодорхойлсон хувилбарыг сонгоно уу.



- A. Диез- Эгшгийг хагас өнгөөр дээшлүүлнэ.
B. Бемоль- Эгшгийг хагас өнгөөр доошлуулна.
C. Стакатто- Эгшгүүдийг огцом тасалдангуй хөгжимдөнө.
D. Легатто- Эгшгүүдийг тасралтгүй үргэлжлүүлэн хөгжимдөнө.
10. Хүний биеийн уян налархай хөдөлгөөнийг тодорхой айзам хэмнэлд оруулан амьдралын үзэгдлүүдийг дүрслэн илэрхийлдэг хөгжмийн урлагийн төрөл аль нь вэ?
A. Бүжиг B. Дуурь C. Ари, романс D. Симфони
11. Монголын хамгийн анхны симфони хэний ямар зохиол болохыг сонгоно уу.
A. Л.Мөрдорж "Миний эх орон" B. Ц.Нацагдорж "Өргөөний баяр наадам"
C. Э.Чойдог "Монголын сайхан орон" D. Б.Шарав "Сэрсэн тал"
12. Дуурь дахь дуулаачийн хөгжмийн төрлүүдийн тухай юу мэдэх вэ? Бүгд зөв байх хувилбарыг сонгоорой.

№	Тайлбар	Нэршил
1	Нийтийн бодол санаа, хүсэл эрмэлзлийг илэрхийлдэг дуулаачийн төрөл	а. Үглэл дуу- Речитатив (recitative)
2	"Уран унших" гэсэн утга бүхий латин үг.	б. Бодрол дуу- Ари (aria)
3	Дуурийн гол дүрийн гол дуу	в. Найрал дуу- Хор (choir)

- A. 1а, 2б, 3в B. 1в, 2а, 3б C. 1в, 2б, 3а D. 1а, 2в, 3б
13. Хоршил, гурвал, дөрвөл дуучдыг дуулаачийн аль төрөлд хамааруулах вэ?
A. Гоцлол дуу B. Найрал дуу C. Цөөхүүл дуу D. Ари
14. Эртний грекийн нийцэл, дуурьсал гэсэн утгатай хөгжмийн урлагийн томоохон төрөл аль вэ?
A. Дуурь B. Бүжгэн жүжиг C. Ари, романс D. Симфони
15. Зургаас модон үлээвэр хөгжмийн бүрэлдэхүүнийг сонгоно уу.

